



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.9, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 3.6-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цөмийн бодистой холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг 1 дүгээр, “Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягт”-ыг 2 дугаар, “Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягт”-ыг 3 дугаар, “Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн загвар”-ыг 4 дүгээр, “Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн загвар”-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Цөмийн энергийн комиссын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

0100053

**ЦӨМИЙН БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасан цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, 15.1.4-д заасан цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах үйл ажиллагаа эрхлэхээр Цөмийн энергийн комисс /цаашид "Комисс" гэх/-оос тусгай зөвшөөрөл /цаашид "Тусгай зөвшөөрөл" гэх/ хүссэн өргөдлийг хүлээн авах, үнэлгээ хийх, тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах дотоод үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын 1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Цөмийн энергийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, норм, дүрэм, журмыг баримтална.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн төрөл, хугацаа

2.1. Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч /цаашид тусгай зөвшөөрөл хүсэгч гэх/-д Комиссоос дараах төрлийн тусгай зөвшөөрлийг олгоно. Шаардлагатай тохиолдолд нэгтгэн олгож болно.

- 2.1.1. цөмийн бодис эзэмших,
- 2.1.2. цөмийн бодис ашиглах
- 2.1.3. цөмийн бодис худалдах;
- 2.1.4. цөмийн бодис импортлох,
- 2.1.5. цөмийн бодис экспортлох,
- 2.1.6. цөмийн бодис тээвэрлэх,
- 2.1.7. өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлах.

2.2. Комисс нь Цөмийн энергийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасны дагуу 15.1.3, 15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.

Гурав. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авах, магадлан шалгах

3.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг энэ журмын маягт 1, маягт 2-ын дагуу бүрдүүлэн, өргөдлийн маягтад эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан Комиссын Ажлын албанд цахимаар эсвэл албан бичгээр ирүүлнэ.

3.1.1. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.1-т заасан баримт бичиг;

3.1.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3, 34.1.4, 34.1.5-д заасан улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

3.1.3. Цөмийн энергийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1-т заасан шаардлагыг хангасан талаар нотлох баримт (танилцуулга, тайлан мэдээ, хөтөлбөр, хөндлөнгийн байгууллагын судалгаа дүгнэлт зэрэг);

3.2. Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан тусгай зөвшөөрөл олгоход Цөмийн энергийн тухай хуулийн 33 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 39, 40, 42 дугаар зүйл, энэ журмын 2.1.3, 2.1.4, 2.1.6, 2.1.7-д заасан шаардлагуудыг тус тус хангуулна.

3.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт зөвшөөрөл хүссэн өргөдөлд тусгай зөвшөөрлийг

авахад бүрдүүлсэн баримт бичиг буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3-т заасан баримт бичгийг дахин шаардахгүй.

3.4.Комиссын Ажлын алба нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тусгана.

3.5.Комиссын Ажлын албаны тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь өргөдлийн материалыг хүлээн аваад дараах ажиллагааг явуулна.

3.5.1.Өргөдлийн материалыг хүлээн авснаас хойш Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2-т заасны дагуу ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг маягт 1, маягт 2-ын дагуу шалгах;

3.5.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 3-т заасны дагуу энэ журмын 3.5.1-т заасан арга хэмжээний талаар зөвшөөрөл хүсэгчид баримт бичгийн бүрдлийг шалгах хугацаанд багтаан цахимаар эсвэл албан бичгээр мэдэгдэнэ. Нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг тус бүрийн талаар мэдэгдэлд тодорхой тусгана.

3.5.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 4-т заасны дагуу баримт бичиг нөхөн бүрдүүлэх хугацаа 30 хүртэл ажлын өдөр байх ба энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй тохиолдолд өргөдөл гаргаагүйд тооцож энэ тухай тусгай зөвшөөрөл хүсэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.5.4.Тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч баримт бичгийн бүрдэл шаардлага хангасан гэж үзвэл магадлан шалгах, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах саналыг Комиссын Ажлын албаны даргад танилцуулна.

3.6. Хуулийн этгээд зөвшөөрөл авах болон сунгуулах хүсэлт илгээхэд "тусгай зөвшөөрлийн цахим систем" (цаашид "систем" гэх)-ийг ашиглана.

3.7. Журмын 3.6-д заасан системд хандан хүсэлт гаргах хуулийн этгээд нь цахим тайлангийн систем /etax.mta.mn/-д нэвтэрч холбогдох тохиргоог хийж Татварын удирдлагын нэгдсэн системээс холбогдох мэдээллийг татах ба хэрэв бүртгэлгүй тохиолдолд дараах мэдээллийг кирилл үсгээр бичиж бүртгүүлнэ:

- 3.7.1.Байгууллагын регистрийн дугаар;
- 3.7.2.Байгууллагын даргын овог, нэр;
- 3.7.3.цахим шуудан (email)-ийн хаяг;
- 3.7.4.холбогдох утасны дугаар;

3.8. Зөвшөөрлийн төрлөөс хамаарч хүсэлт гаргагчийн холбогдох мэдээллийг систем автоматаар шалгах бөгөөд нэмэлтээр шаардагдах баримт бичгийг системээс өгөгдөх зааврын дагуу цахим хэлбэрээр хавсаргана.

Дөрөв. Үнэлгээ хийх, санал авах

4.1.Комиссын Ажлын албаны даргын тушаалаар өргөдлийн материалд үнэлгээ хийх, магадлан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна.

4.2.Ажлын хэсэг энэ журмын 3.1-т заасан материалд хавсралт 1-т заасны дагуу шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлгээ хийнэ. Үнэлгээг 3 сарын дотор хийж дуусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд 1 сараар сунгаж болно.

4.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 6-д заасны дагуу тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь магадлан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.13-т заасны дагуу холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авна.

4.4.Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11-т заасны дагуу өргөдлийн баримт бичгийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллага (улсын байцаагчийн дүгнэлт болон бусад холбогдох дүгнэлт, хяналтын хуудас, тодорхойлолт, лабораторийн дүн шинжилгээ)-аас гаргуулан авах, хөндлөнгийн шинжээчээр шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэж болох бөгөөд холбогдох зардлыг өргөдөл гаргагч хариуцна. Энэ тухай тусгай зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэнэ.

4.5.Цөмийн энергийн тухай хуулийн 15.1.3, 15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдлийн материалыг Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-д заасны дагуу тагнуулын төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тусгай зөвшөөрөл олгох эсэхэд санал авах ажлыг зохион байгуулна.

4.6.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8-д заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тусгай зөвшөөрөл олгох эсэхэд санал авах хугацаа 30 хүртэл ажлын өдөр байна.

4.7.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянаж, үнэлгээ хийж, тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг үйл ажиллагааны онцлогийг харгалзан 6-12 сарын хугацаанд шийдвэрлэнэ.

4.8.Ажлын хэсэг үнэлгээний дүнг хэлэлцэн нэгдсэн үнэлгээний дүнг Комиссын нарийн бичгийн даргад танилцуулна.

4.9.Комиссын Ажлын алба нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, ажлын хэсгийн үнэлгээний дүн болон холбогдох баримт бичгийн хамт Комиссын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

Тав. Тусгай зөвшөөрөл олгох

5.1.Комиссын Нарийн бичгийн дарга тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Комиссын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.2.Комиссын хуралдаанаас төрийн байгууллагын санал болон үнэлгээний дүгнэлтийг хэлэлцэж, тусгай зөвшөөрөл олгох, эс олгох тухай тогтоол гаргана.

5.3.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 7-д заасны дагуу зөвшөөрөл олгох шийдвэр болон улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ, төлөх хугацааны талаар тухайн шийдвэр гарсан өдөрт багтаан зөвшөөрөл хүсэгчид цахимаар эсвэл албан бичгээр мэдэгдэнэ.

5.4.Комиссын тогтоолын дагуу тусгай зөвшөөрлийн баримт бичгийг олгох үйл ажиллагааг Комиссын Ажлын албанаас зохион байгуулна.

5.5.Тусгай зөвшөөрлийн баримт бичигт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэршил, тоо, хэмжээ, агуулахын болон хадгалах байршлын талаарх мэдээлэл зэргийг тусгах бөгөөд тусгай зөвшөөрөл нь цөмийн бодисын алдагдал, хоргодол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг тусгах хавсралттай байна.

5.6.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10-т заасны дагуу Зөвшөөрөл олгохоос татгалзсан бол мэдэгдэлд татгалзсан үндэслэлийг тодорхой заах ба мэдэгдлийг мэдэгдэл гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор зөвшөөрөл хүсэгчид албан бичгээр хүргүүлнэ.

5.7.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 11-т заасны дагуу тухайн зөвшөөрөл хүсэгчээс зургаан сарын дотор уг чиглэлээр хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

5.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 9 болон Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дугаар тогтоолоор батлагдсан Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журмын 2.8, 2.9-д заасны дагуу зөвшөөрөл олгосон шийдвэрийг Эдийн

засгийн хөгжлийн яаманд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор хүргүүлж, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

5.9.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 8-д заасны дагуу шийдвэр гаргасан өдрөөс хойш тав хоногийн дотор зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу QR код бүхий зөвшөөрлийн баримт бичгийг цахимаар олгоно

Зургаа. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах

6.1.Тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 1-д заасны дагуу зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө түүнийг сунгуулах тухай мэдэгдлийг зөвшөөрөл эзэмшигчид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу системээс мэдэгдэл хүргүүлнэ, энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас нэгээс доошгүй сарын өмнө хугацаа сунгуулах тухай өргөдлийг Комиссын Ажлын албанд гаргана. Зөвшөөрөл тус бүрийн бүрдүүлэх материал болон байнгын шалгуур хангаж байгаа эсэхээс хамаарч сунгалт хийх процессыг шаардлагатай шат дамжлага хүртэл автоматаар хийнэ.

6.3.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай өргөдөлд Цөмийн энергийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

6.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 3-т заасны дагуу Комиссын Ажлын алба нь өргөдлийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй бөгөөд өргөдлийг хүлээн авсан тухай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, энэ тухай бүртгэлд тэмдэглэнэ.

6.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 4-т заасны дагуу тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх талаар зөвшөөрөл эзэмшигчид цахимаар эсвэл албан бичгээр мэдэгдэнэ. Нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг тус бүрийн талаар мэдэгдэлд тодорхой тусгана.

6.6.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 6-д заасны дагуу баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа арав хоног байна. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол зөвшөөрлийг сунгуулах тухай өргөдөл гаргаагүйд тооцно.

6.7.Тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь баримт бичгийн бүрдэл шаардлага хангасан гэж үзвэл магадлан шалгах, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах саналыг Комиссын Ажлын албаны даргад танилцуулна.

6.8.Комиссын Ажлын албаны даргын тушаалаар өргөдлийн материалд үнэлгээ хийх, магадлан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна.

6.9.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 6-д заасны дагуу ажлын хэсэг магадлан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.13-т заасны дагуу холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авна.

6.10.Ажлын хэсэг үнэлгээ хийж, дүнг Комиссын Ажлын албаны даргад танилцуулна.

6.11.Комиссын Ажлын алба нь ажлын хэсгийн үнэлгээний дүн болон холбогдох баримт бичгийн хамт Комиссын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

6.12.Цөмийн энергийн энергийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасны дагуу өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдөрт багтаан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан нөхцөл,

шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

6.13.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 18-т заасны дагуу шийдвэрийг тухайн шийдвэр гарсан өдөрт багтаан зөвшөөрөл эзэмшигчид цахимаар эсвэл албан бичгээр мэдэгдэнэ.

6.14.Зөвшөөрөл олгох болон сунгахад эрх бүхий байгууллага зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг системээс цахим хэлбэрээр, бодит цагийн горимоор зөвшөөрлийн нэгдсэн санд хүргүүлнэ

Долоо. Баримт бичгийн сан үүсгэх, архивлах

7.1.Зөвшөөрөл хариуцсан албан хаагч хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд тус бүрд цахим хувийн хэрэг үүсгэн архивлана.

7.2.Цахим архив нь дараах бүрдэлтэй байна:

7.2.1.зөвшөөрөл олгосон болон дуусах огноо;

7.2.2.сунгалт хийсэн огноо;

7.2.3.зөвшөөрлийн нөхцөл зөрчсөн эсэх тухай тэмдэглэл;

7.2.4.түдгэлзүүлсэн эсэх, түүний дуусах огноо;

7.2.5.Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн эсэх.

7.3.Зөвшөөрлийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн, зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн нэрийг өөрчлөн гэрчилгээ олгосон тухай бүр тухайн зөвшөөрлийг хариуцсан албан хаагч өөрчлөлтийг цахим системд оруулна.

Найм. Бусад

8.1.Тусгай зөвшөөрөл хариуцсан албан хаагч нь зөвшөөрлийн бүртгэлийг хөтөлж, Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу мэдээллийн нэгдсэн санд тусгай зөвшөөрлийн хүссэн тухай болон сунгуулах өргөдлийн шийдвэрлэлтийн явц, олгосон хугацаа, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулна.

8.2.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-д заасны дагуу зөвшөөрлийн талаарх шийдвэрийг ажлын таван өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон нийтэд тус тус мэдээлнэ.

xxxXXXXxx



Цөмийн энергийн комиссын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт



**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБА**

**ЦӨМИЙН БОДИС ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮССЭН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

Өргөдлийн дугаар

Огноо: (он/сар/өдөр)

Хуулийн этгээдийн нэр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар:

Өргөдөл гаргагчийн нэр: (Овог, нэр)

Албан тушаал:

Цөмийн бодис эзэмших, ашиглах байршил:

	Аймаг (хот)	Сум (дүүрэг)
1.		
2.		
3.		

..... тн (хэмжээ) бүхий цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргаж байна.

д/д	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1	Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт (баталсан маягтын дагуу)	☐	☐
2	Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албаны)	☐	☐
3	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм (нотариатаар гэрчлүүлсэн)	☐	☐
4	Цөмийн бодис агуулах талбайн байршил, булангийн цэгүүдийн солбицлыг буулгасан зураг (3 хувь)	☐	☐
5	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	☐	☐
6	Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-19.1.9-д заасан баримт бичгүүд. Үүнд:	☐	☐
	Эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл	☐	☐

	Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга, дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагчийн мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ	☐	☐
	Эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	☐	☐
	Үйл ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандартын шаардлага хангасан талаарх төрийн захиргааны байгууллагын үнэлгээ	☐	☐
	Цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	☐	☐
	Цөмийн болон цацрагийн аюулгүй байдалд дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр	☐	☐
	Болзошгүй цөмийн болон цацрагийн осол, сүйрлийн хор уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга	☐	☐
	Цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлт	☐	☐
7	Олборлосон эсвэл олборлох ураны хүдэр, ураны хүдрийн баяжмал болон бусад дагалдах бүтээгдэхүүний тоо, хэмжээ, агуулгын талаарх мэдээлэл	☐	☐
8	Цөмийн бодис дахь элементүүдийн агуулга, тоо хэмжээг тодорхойлсон лабораторийн дүн, шинжилгээ	☐	☐
9	Олборлолт болон боловсруулалтын үйл ажиллагаанаас үүссэн эсвэл үүсэх хаягдлын талаарх мэдээлэл	☐	☐
10	Цөмийн бодис хадгалах байгууламжийн үндсэн мэдээлэл (ерөнхий зохион байгуулалт, газрын зураг, бүдүүвч зураг, байгууламжид нэвтрэх маршрут гэх мэт), эзэмшигчийн нэр, хяналтын (safeguards) асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тухайн байгууламжид гүйцэтгэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны төлөвлөгөө	☐	☐
11	Хяналтын (safeguards) хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, эрх бүхий албан тушаалтны нэр болон холбоо барих мэдээлэл, баталгааны асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл, холбогдох дүрэм, журам	☐	☐
12	Цөмийн бодис, цөмийн материалын биет хамгаалалтыг хангах талаарх мэдээлэл	☐	☐
13	Цөмийн бодис, цөмийн материалын дотоод бүртгэлийн системийн мэдээлэл (мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, аюулгүй байдлын зааварчилгаа ба түүний хуулбарууд)	☐	☐
14	Материалын тэнцлийн талбай байршил болон цөмийн материалын тооллого, урсгалыг хянах хэмжилтийн гол цэг болон стратегийн цэгийн мэдээлэл	☐	☐

15	Цөмийн бодис, цөмийн материалын тоо хэмжээг тодорхойлох үнэлгээний арга болон тооцоо, хэмжилт хийх үйл ажиллагааны талаарх мэдээлэл	☐	☐
16	Бүртгэлтэй холбоотой биет тооллого явуулах үйл ажиллагаа болон давтамжийн талаарх мэдээлэл	☐	☐
17	Цөмийн материалын багцуудыг тодорхойлох техникийн үзүүлэлт	☐	☐
18	Цөмийн материалын урсгалын хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглах хязгаарлалтын болон ажиглалтын системийн талаарх мэдээлэл	☐	☐
19	Баталгаатай холбоотойгоор байгууламжид дотоодын болон олон улсын байцаагчдыг нэвтрүүлэх журам	☐	☐

Тамга

Өргөдөл гаргагч: (.....)

(гарын үсэг)

(овог, нэр)

.....

(огноо)

Тайлбар: Дээр заасан нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

1. "цөмийн бодис" гэж Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг;
2. "цөмийн материал" гэж Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д заасан цөмийн реактор болон цөмийн зэвсэгт ашиглагддаг материалыг;
3. "Материалын тэнцлийн талбай" гэж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан цөмийн материалын хэмжээг байгууламжийн дотогш болон гадагш шилжүүлэх бүрт тодорхойлж болох талбай, хяналт хийх зорилгоор онцгой үед цөмийн материалын биет тооллого явуулж болох талбайг мөн хэлнэ. Эдгээр талбай нь цөмийн бодис, цөмийн материал хадгалах байгууламжийн гадна болон дотор байж болно;
4. "Багц" гэж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан цөмийн материалын бүртгэл тооллогын үндсэн элементийг хэлнэ. Багцыг тусгай ID дугаараар тодорхойлох ба тухайн багц тус бүрт цөмийн материалын хэмжээг нэг бүрчлэн зааж өгнө. Багцад нэг, түүнээс дээш зүйл байж болно. Бараа материалын бүртгэлийн үндсэн цэгүүд нь материалын тэнцлийн хэсэгт байгаа бүх цөмийн материалыг хэмжихээс эхэлнэ.
5. "Стратегийн цэг" гэж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан хэвийн нөхцөлд стратегийн бүх цэгээс авсан мэдээлэлтэй хослуулах үед хяналтын арга хэмжээний хэрэгжилтийг хангахад шаардагдах мэдээлэл хангалттай байхаар шалгагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн, загварын мэдээллийг шалгах явцад сонгосон байршлыг хэлнэ. Тоо бүртгэлийн материалын тэнцэл хийхэд хамаарах гол хэмжилтүүдийн байршил болон хязгаарлалт ба тандалт хийгдэх аливаа байршлыг стратегийн цэгт оруулж болно.

Хуулийн этгээдийн тодорхойлолт

1. Хуулийн этгээдийн нэр:

2. Регистрийн дугаар:

3. Өмчийн хэлбэр:

Хувийн

☐

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой

☐

Төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь

4. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн тоо:

Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн нэр:

Хувь, эзэмшил:

.....

.....

.....

.....

.....

.....

5. Тусгай зөвшөөрлийн асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтны мэдээлэл:

.....

.....

6. Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг: **(Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.1.3-д заасны дагуу)**

Гудамж/байшин/, хаалганы дугаар:

Баг/ хороо:

Сум/ дүүрэг:

Аймаг/ хот:

Байршлын код:

Шуудангийн салбар/хайрцаг:

Утас:

Факс:

Гар утас:

Цахим шуудангийн хаяг:

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан:

Тамга

(.....)
(гарын үсэг)

Эрх бүхий албан тушаалтны нэр
(овог, нэр)

Тодорхойлолтыг хүлээн авч бүртгэсэн:

(.....)
(гарын үсэг)

Эрх бүхий албан хаагч
(овог, нэр)



Цөмийн энергийн комиссын 2023 оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт



**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБА**

**ЦӨМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХ, ТЭЭВЭРЛЭХ,
ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮССЭН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

Өргөдлийн дугаар.....

Огноо: (он/сар/өдөр)

Хуулийн этгээдийн нэр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар:

Өргөдөл гаргагчийн нэр: (овог, нэр)

Албан тушаал:

1. Цөмийн бодис тээвэрлэх маршрут:

.....
.....

2. Цөмийн бодис импортлох боомт, маршрут:

.....
.....

3. Цөмийн бодис экспортлох боомт, маршрут:

.....
.....

4. Хаягдлыг булшлах газар, талбайн байршил:

.....
.....

дагуу цөмийн бодис импортлох, экспортлох, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл хүсч,
өргөдөл гаргаж байна.

д/д	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Өргөдөл гаргагч хавсаргав	Өргөдөл хүлээн авагч хүлээн авав
1	Өргөдөл гаргагчийн албан ёсны тодорхойлолт (баталсан маягтын дагуу)	☐	☐
2	Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албаны)	☐	☐
3	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм (нотариатаар гэрчлүүлсэн)	☐	☐
4	Цөмийн бодис агуулах талбайн байршил, булангийн цэгүүдийн солбицлыг буулгасан зураг (3 хувь)	☐	☐

5	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	☐	☐
6	Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-19.1.9-д заасан баримт бичгүүд. Үүнд:	☐	☐
	Эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл	☐	☐
	Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга, дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагчийн мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ	☐	☐
	Эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	☐	☐
	Үйл ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандарт, шаардлага хангасан талаарх төрийн захиргааны байгууллагын үнэлгээ	☐	☐
	Цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	☐	☐
	Цөмийн болон цацрагийн аюулгүй байдалд дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр	☐	☐
	Болзошгүй цөмийн болон цацрагийн осол, сүйрлийн хор уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга	☐	☐
	Цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлт	☐	☐
	Цацраг идэвхт хаягдлын тоо хэмжээ, төлөв, түүний менежментийн хөтөлбөр, төлөвлөгөө	☐	☐
7	Олборлосон эсвэл олборлох ураны хүдэр, ураны хүдрийн баяжмал болон бусад дагалдах бүтээгдэхүүний тоо, хэмжээ, агуулгын талаарх мэдээлэл	☐	☐
8	Цөмийн бодис дахь элементүүдийн агуулга, тоо хэмжээг тодорхойлсон лабораторийн дүн, шинжилгээ	☐	☐
9	Олборлолт болон боловсруулалтын үйл ажиллагаанаас үүссэн эсхүл үүсэх хаягдлын талаарх мэдээлэл	☐	☐
10	Ачуулах цөмийн бодис, цөмийн материалын нийт хэмжээ, түүнд хамаарах материалын агууламжийг изотопоор, химийн найрлагаар, физик хэлбэрээр илэрхийлсэн мэдээлэл	☐	☐
12	Тээвэрлэлтийн чингэлгийн төрөл (экспортлох тохиолдолд битүүмжлэх боломжуудын техникийн үзүүлэлтүүд)	☐	☐
13	Экспортлох тохиолдолд хүрэх газар, улс, импортлох тохиолдолд материалын сав баглааг задлах материалын тэнцлийн хэсэг болон байршлын талаарх мэдээлэл	☐	☐
14	Тээвэрлэлтийн төрөл, маршрутын талаарх мэдээлэл	☐	☐
15	Экспортлох тохиолдолд ачааг бэлтгэх газрын талаарх мэдээлэл	☐	☐
16	Тээвэрлэлтийн бүртгэлийн системийн талаарх мэдээлэл (Экспортлох тохиолдолд цөмийн бодисыг тодорхойлох, тоо хэмжээ болон найрлагыг шалгах, импортлох	☐	☐

тохиолдолд цөмийн бодис агуулсан ачааг буулгаж, задлан түүний хэмжээ болон найрлагыг магадлан шалгах үйл ажиллагаа)		
---	--	--

Тамга

Өргөдөл гаргагч: (.....)
(гарын үсэг) (овог, нэр)

.....
(огноо)

Тайлбар: Дээр заасан нэр томъёог дараах байдлаар ойлгоно.

1. “цөмийн бодис” гэж Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг;
2. “цөмийн материал” гэж Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д заасан цөмийн реактор болон цөмийн зэвсэгт ашиглагддаг материалыг;
3. “Материалын тэнцлийн талбай” гэж Олон улсын атомын энергийн агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан цөмийн материалын хэмжээг байгууламжийн дотогш болон гадагш шилжүүлэх бүрт тодорхойлж болох талбай; хяналт хийх зорилгоор онцгой үед цөмийн материалын биет тооллого явуулж болох талбайг мөн хэлнэ. Эдгээр талбай нь цөмийн бодис, материал хадгалах байгууламжийн гадна болон дотор байж болно;
4. “Багц” гэж Олон улсын атомын энергийн агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан цөмийн материалын бүртгэл тооллогын үндсэн элементийг хэлнэ. Багцыг тусгай ID дугаараар тодорхойлох ба тухайн багц тус бүрт цөмийн материалын хэмжээг нэг бүрчлэн зааж өгнө. Багцад нэг, түүнээс дээш зүйл байж болно. Бараа материалын бүртгэлийн үндсэн цэгүүд нь материалын тэнцлийн хэсэгт байгаа бүх цөмийн материалыг хэмжихээс эхэлнэ.
5. “Стратегийн цэг” гэж Олон улсын атомын энергийн агентлагийн баталгааны тайлбар толь (IAEA Safeguards glossary)-д заасан хэвийн нөхцөлд стратегийн бүх цэгээс авсан мэдээлэлтэй хослуулах үед хяналтын арга хэмжээний хэрэгжилтийг хангахад шаардагдах мэдээлэл хангалттай байхаар шалгагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн, загварын мэдээллийг шалгах явцад сонгосон байршлыг хэлнэ. Тоо бүртгэлийн материалын тэнцэл хийхэд хамаарах гол хэмжилтүүдийн байршил болон хязгаарлалт ба тандалт хийгдэх аливаа байршлыг стратегийн цэгт оруулж болно.

Цөмийн энергийн комиссын 2023 оны
08 дугаар сарын 02-ны өдрийн 4 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИСС

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар

Монгол Улсын "Цөмийн энергийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3,
Цөмийн энергийн комиссын 20.... оны дугаар/дүгээр сарын -ны/ний
өдрийн тоот тогтоолыг үндэслэн
аймаг/нийслэлийнсум/дүүргийн-д

/улсын бүртгэлийн дугаар/

/регистрийн дугаар/

цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг 20.... оны -р сарын -ны/ний өдрөөс 20.... оны-р сарын
....-ны/ний өдөр хүртэл жилийн хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралтын хамт хүчинтэй.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА...../

/

20.... оны -р сарын -ны өдөр
Улаанбаатар хот

Цөмийн энергийн комиссын 2023 оны
08 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

УХА/1230 5052506



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИСС

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар

Монгол Улсын "Цөмийн энергийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4,
Цөмийн энергийн комиссын 20.... оны дугаар/дүгээр сарын -ны/ний
өдрийн тоот тогтоолыг үндэслэн
аймаг/нийслэлийнсум/дүүргийн-д

/улсын бүртгэлийн дугаар/

/регистрийн дугаар/

цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 20.... оны -р сарын -ны өдрөөс
20.... оны-р сарын-ны өдөр хүртэл жилийн хугацаагаар
олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралтын хамт хүчинтэй.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА...../

/

20.... оны -р сарын -ны өдөр
Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАВСРАЛТ

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй

№	Үйл ажиллагааны төрөл	ЦӨМИЙН БОДИС					Хэмжээ (Kg)	Огноо гарын үсэг, тэмдэг
		Нэр		Химийн томъёо	Бүтээгдэхүүн дэх уран (тори)-ын агууламж (хувь %)	Физикийн төлөв		
		Монгол	Олон Улсын					
1	Импорт							
2	Экспорт							
3	Тээвэрлэх							
4								